



2025 оны 10 дугаар сарын 28-ний өдөр

ТОГТООЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

"Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.10-т "хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг" гэж заасан бөгөөд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах нь хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гол үйл ажиллагаа юм.

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн тогтворжуулах татварын орчныг Хөрөнгө оруулалтын тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу тогтоох, чөлөөт бүсэд мөрдөгдөх татварын тусгай дэглэмийг Чөлөөт бүсийн тухай хуулиар тогтоож, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг татварын холбогдох хуулиар зохицуулахаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй" гэж.

Мөн гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт "Экспортын барааны гаалийн тариф болон импортын барааны нэн тааламжтай тарифыг Улсын Их Хурал тогтооно." гэж, 4.8 дахь хэсэгт "Гаалийн тарифыг түр хугацаагаар тогтоож болох бөгөөд ийнхүү түр хугацаагаар тогтоосон тарифыг мөрдөх хугацаа жилд 6 сараас хэтрэхээргүй байна." гэж, 4.9 дэх хэсэгт "Гаалийн тарифыг хилийн боомтоор тогтоож болно." гэж тус тус заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.4.2.1-д "Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ." гэж.

Улсын Их Хурлын 2025 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 60 дугаар тогтоолын 6 дахь хэсэгт “алслагдсан бүс нутгийн гурил, тэжээлийн үйлдвэрлэл, хангалтыг хэвийн түвшинд хүртэлх хугацаанд үнийн өсөлтөд голлон нөлөөлж буй тээврийн зардлыг бууруулах, шаардлагатай гурил, малын тэжээлийг тухайн бүс нутгийн хилийн боомтоор оруулж үнийн болон хангалтын тогтвортой байдлыг бий болгох,” гэж тус тус заасан.

1.2.Практик шаардлага

Манай улсын газар тариалан, мал аж ахуй, хүнсний салбарын үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлт болон олон улсын харилцаанаас үүдэн гарсан үр дагаварууд, эдийн засгийн таагүй нөлөөнд мэдрэг байсаар байгаа бөгөөд цаашид үүсэж болзошгүй нөхцөл байдлыг харгалзан үзэж цаг үеийн шинжтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр гаалийн албан татвартай холбоотой хууль, тогтоомжийг өргөн мэдүүлсээр ирсэн.

Тухайлбал өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй даван туулах, хүн амын хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах, стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх зорилгоор 2014-өөс 2025 оны хооронд улаанбуудай, улаанбуудайн гурил болон малын тэжээлийг гаалийн албан татвараас чөлөөлөх хүрээнд нийт найман удаа тусгайлан хууль баталсан.

Мөн Улсын Их Хурлын 2008 оны Засгийн газарт эрх олгох тухай 42 дугаар тогтоолоор улаанбуудайн гурил, хөх тарианы гурил, улаанбуудай-хөх тарианы гурилын гаалийн тарифын хувь хэмжээг өөрчлөн тогтоох эрхийг Засгийн газарт өгсний дагуу Засгийн газрын 2008 оны 235 дугаар тогтоолоор гаалийн тарифын хувь хэмжээг тодорхой хугацаанд “0” хувь болгон өөрчилж байсан билээ.

Улмаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганаар “Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор импортлох мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөх” тухай хуулийг хэлэлцэн баталсан.

Уг хуулийн хүрээнд гаалийн албан татварыг чөлөөлж хилийн боомтуудаар орж ирэх улаанбуудайн гурил болон мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийн хэмжээ анх тооцоолсноос дариу 2-3 дахин их буюу 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 64.2 мян.тн улаанбуудайн гурил, 65.2 мян.тн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 24.2 мян.тн улаанбуудайн гурил импортолсон байна.

Гэвч хууль батлагдсантай холбоотойгоор 2024 онд улаанбуудайн тариалалт эрс буурч 300.4 мян.га талбайгаас 386.4 мян.тонн ургац хураан авсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад тариалсан талбай 35.4 мян.га-аар, хураан авсан ургацын хэмжээ 57.0 мян.тонноор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Харин улсын хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж буй 9 гурилын үйлдвэр 2024 онд нийт хүчин чадлын 30 хувийг ашиглан 148.4 мян.тн гурил үйлдвэрлэж, гурилын хэрэгцээний 59.1 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 40.9 хувийг импортоор авснаар дотоодын гурил үйлдвэрлэл 40 хувиар буурсан үзүүлэлт гарсан.

Хэдийгээр хуулийн хэрэгжилтийн хүрээнд гурилын нийлүүлэлт нэмэгдэж, үнэ тогтворжсон эерэг үр дүн гарсан боловч энэ нь улаанбуудайн гурил үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд нөлөөлөөд зогсохгүй манай улсын эдийн засгийн тулгуур салбаруудын нэг болох хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж, цаашлаад салбарын хэмжээнд үйлдвэрлэлийн тасалдал үүсгэх нөхцөл байдал бүрдсэн.

Улмаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганаар дээрх арга хэмжээг зогсоож, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэн баталсан байна.

Харин сүүлийн үед байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан баруун бүсийн хэмжээнд хур тунадас бага, гантай байснаас улбаалан малын өвс, тэжээлийн гарц муу, улаанбуудайн ургац хураалт өмнөх жилүүдээс харьцангуй бага байх төлөвтэй зэрэг тариалангийн үйлдвэрлэлийн бодит нөхцөл байдалд тулгуурлан улаанбуудайн гурил, мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийн хангамж, нийлүүлэлт тухайн бүс нутагт доголдох нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Цаашлаад цаг үеийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах, тэр дундаа хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байдлыг хангаж, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор улаанбуудайн гурил болон малын тэжээлийг гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлага үүсч байна.

Үүний хүрээнд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нэг болох улаанбуудайн гурил болон малын тэжээл, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний гаалийн албан татварыг Улсын Их Хурлаас баталсан тогтоолд заасан хязгаарт багтаан тогтоох эрхийг Засгийн газарт олгох зайлшгүй шаардлагатай байна.

Иймд хөдөө аж ахуйн салбарт үүссэн бодит нөхцөл байдлыг харгалзан үзэж Монгол Улсын Их Хурлын 1999 оны "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төслийг "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах төслийн хэлбэрээр боловсруулна.

Тогтоолын төслийг таван зүйлтэй байхаар боловсруулна. Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлд "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын "08," гэсний дараа "10 дугаар бүлгийн 1002.90.20, 1003.90.20, 1004.90.20, 1005.90.20 дахь үндэсний код, 11 дүгээр бүлгийн 11.01 дэх зүйл," гэж, "22.09 дэх зүйл," гэсний дараа "23 дугаар бүлгийн 23.02 дахь зүйл," гэж, 2 дугаар зүйлд "тогтоолын хавсралтаар баталсан "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ"-ний 10 дугаар бүлэгт 1002.90.20- тэжээлийн (Хөх тариа), 1003.90.20 -тэжээлийн (Арвай), 1004.90.20 -

тэжээлийн (Овьёос), 1005.90.20 -тэжээлийн (Эрдэнэшиш) агуулгатай үндэсний кодыг нэмж, Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор тус тус импортолсон бол татварын хувь, хэмжээг 5 хүртэл байхаар, 3 дугаар зүйлд “тогтоолын хавсралтаар баталсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ”-ний 23 дугаар бүлэгт 23.02 -(Үр тариа ба буурцагт ургамлыг шигших, тээрэмдэх эсвэл бусад боловсруулалт хийх явцад гардаг хорголжилсон, эсвэл хорголжлоогүй хивэг, үртэс болон бусад үлдэгдэл) агуулгатай зүйл нэмж, Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор импортолсон бол татварын хувь, хэмжээг 5 хүртэл байхаар, 4 дүгээр зүйлд “тогтоолын хавсралтаар баталсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ”-ний 11 дүгээр бүлгийн “7 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1 хүртэл” гэсэн хугацаанд заасан албан татварын хувь, хэмжээний “15” гэсний дараа “хүртэл” гэж, мөн бүлгийн “4 дүгээр сарын 1-нээс 7 дугаар сарын 1 хүртэл” гэсэн хугацаанд заасан албан татварын хувь, хэмжээний “5” гэсний дараа “хүртэл” гэж тус тус нэмж, 5 дугаар зүйлд тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн

Тогтоолын төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар гарахаар байна.Үүнд:

- Стратегийн хүнсний хангамжийн тогтвортой байдал, нөөц бүрдүүлэхэд тасалдал үүсэхгүй байх ба сөрөн тэсвэрлэх чадавх бэхэжнэ.

- Алслагдсан бүсийн хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нэг болох улаанбуудайн гурилын хангамж, нөөц тасалдахгүй байх, байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалсан малын тэжээлийн хомсдол үүсэж болзошгүй хүндрэлийг даван туулахад тухай бүр Засгийн газрын хүрээнд шийдвэр гаргах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Тогтоол гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах хууль байхгүй.

-----oOo-----